

ФУНКЦИОНАЛИЗМ

Т. Энхтунгалаг - МУИС, НШУС, Философийн тэнхим, магистр

Мянга мянган жилийн туршид философичид болон теологичид хүний оюун ухааны мөн чанарын тухай хэлэлцсээр иржээ. Олон сонирхолтой онолууд дэвшүүлэгдэж байсан ч энэхүү урт түүхийн туршид голлох онолууд нь хүний оюун ухаан бол ихээхэн нууцлаг шинжтэй, байгаль ертөнц дээрх бусад зүйлсээс зарчмын хувьд эрс ялгаатай хэмээн тооцож байжээ. Ийм таамаглалын үүднээс бол оюун ухаан нь шинжлэх ухааны аргуудаар судлаж мөн чанарыг нь тайлбарлахад бэрх зүйл юм.

Энэ өгүүллийн хүрээнд бид оюун санааны философи дахь нөлөө бүхий онолын нэг функционализмыг авч үзэх болно.

Хэдийгээр функционализм нь социологи, психологи, хэл шинжлэл, архитектур гэх мэт олон салбар ухаанд өргөн хэрэглэгддэг ч энд бид оюун санааны философи дахь функционалист онолын үүсэл, хөгжил, өнөөгийн байдлын талаар голлон хэлэлцэх юм. Функционализм нь орчин үеийн оюун санааны философид адилсалын онол, бежавиоризмтай зэрэгцэн хөгжиж буй онол бөгөөд олон талаараа бежавиоризм болон адилсалын онолын дутагдалтай талуудыг даван туулж чадсан гэж судлаачид үздэг.

Үндсэн санаа

Функционализмын үүднээс оюуны (mental) төлөвүүд (итгэл, үнэмшил хүсэл, өвдөлт) нь өөрсдийн гүйцэтгэх үүргээр тодорхойлогдох бөгөөд эдгээр нь өөр хоорондоо болон, мэдрэхүйн мэдээлэлүүд буюу оролт, зан үйл болох гаралтуудтай шалтгаант холбоотой байдаг ажээ. Ийнхүү гол утгын хувьд функционализм нь оюун ухаан болон оюуны төлөвүүд нь тодорхой байдлаар зохион байгуулагдсан системийн дотор гүйцэтгэх үүрэг болон үйлдлээрээ тодорхойлогддог гэж үздэг онол юм. Функционализмын үүднээс оюун санаа нь аль нэг өвөрмөц субстанц эсвэл суурь субстратаас тогтдог гэдгээрээ биш, харин системтэй зохион байгуулагдсан байдлаараа мөн холбогдох бүрэлдэхүүн хэсгүүдийнхээ гүйцэтгэж буй үүргүүдээр тодорхойлогддог.

Энд судалгаа шинжилгээний бүтээлд ихээхэн ашиглагддаг “цаг”-ны тухай жишээг тайлбар болгон оруулья. Цагыг аль ч төрлийн материалаар, магадгүй төгсгөлгүй олон төрлийн загвараар хийж болно. Гурвалжин, дөрвөлжин, дугуй гэх мэт янз бүрийн хэлбэртэйгээс гадна, алтан мөнгөн, төмөр, модон зэрэг олон төрлийн цагийг бид мэднэ. Энд тухайн зүйлийг “цаг” болгож буй хамгийн гол зүйл нь түүнийг бүрдүүлж буй эд материал биш, түүний юу хийдэг, ямар үүрэгтэйгээр тодорхойлогдох юм.

Үүний нэгэн адил тухайн төлөвийг оюуны төлөв болгож буй гол зүйл нь түүний юунаас бүтсэн бэ гэдэгт биш, харин түүний юу хийдэг вэ гэдэгт оршино. Ингэж үзсэнээрээ функционализм Рене Декартын уламжлал дахь бие, оюун санааны дуализмаас (Энэ ёсоор оюун санаа бол *res cogitans* буюу сэтгэгч субстанци гэгдэх өвөрмөц төрлийн субстанциас тогтдог гэж үздэг) мөн оюун санаа ба тархины адилсалын онол гэх мэт орчин үеийн монизмоос ялгаатай юм. Адилсалын онол нь оюуны төлөвүүд нь тодорхой төрлийн биологи төлөв, тэр дундаа тодорхой төрлийн материаллаг зүйл тархины төлөвөөс тогтдог гэж үздэг.

Хэдийгээр зарим судлаачид араасаа судалгааны нэлээд хүчин чармайлт дагуулсан энэ онол хэрвээ зорилгоо биелүүлж чадах юм бол оюуны мөн чанарын тухайд бидний ойлгож чадаагүй олон зүйлийг хэлж өгч чадна гэж найддаг ч функционализм одоо ч ихээхэн зөрчил агуулсан онол хэвээр байгааг энд дурдах нь зүйтэй. Энэ онолыг шүүмжлэгчид функционализм нь "оюун"-ы хамгийн чухал аргуудыг нэгтгэн тайлбарлаж чадахгүй гэж үздэг хэдий ч одоогоор энэ онолыг үгүйсгэдэг онолчид ч заримдаа үүнээс давуу онол байхгүй гэж үздэг бөгөөд функционалист хандлагын үүднээс хийсэн судалгааны программууд ихээхэн ач холбогдолтой байгааг хүлээн зөвшөөрдөг юм.

Түүхийн үүднээс аваад үзвэл функционализм уг гарлын хувьд эртнийх боловч үндсэндээ 1960 болон 70-аад оны сүүлчээр боловсруулагдсан онол юм. Функционализмын эхлэл гэж тооцогддог анхны үзэл санаа хэлбэрийн тухай Аристотелийн онолоос үүдэлтэй. Оюун ухаан, сүнс биеэс гадуур оршин байх боломжтой гэж үзсэн Платоны онолын эсрэг Аристотель сүнс оюун санаа бол байгалиас зохион байгуулалт бүхий хүний хэлбэр нь бөгөөд хүнд өөрийнх нь мөн чанарыг олгодог хүч, чадваруудын нийлбэр хэмээн тайлбарладаг.

Зарим судлаачдын үзсэнээр (Блок) функционализм нь физикализмын хоёр үндсэн хувилбар болох логик бехавиоризм, психо-физикийн адилсалын онолд тулгарсан асуудлуудын хариулт болон үүссэн байна.

Логик бехавиоризм нь итгэл, хүсэл, өвдөлт зэрэг оюуны төлөвийг илэрхийлсэн өдөр тутмын нэр томьёо, ойлголтуудыг "жинхэнэ" буюу дотоод зан үйлийг илэрхийлсэн шалгуурын үүднээс илрүүлэн тайлбарлахыг зорьсон байна. (Hempel, Rile 1949). Гол төлөөлөгчид нь Райл, Карнап, Хэмпэл юм. Декартын үзлийг Райл шүүмжлэхдээ түүнийг "Машин дахь хий үзэгдэл" (Ghost in machine) гээд оюун санаа бол бие даасан субстанци, объект гэсэн үзэл бол анхнаасаа категорын алдаатай, "оюун санаа" нь нэр үг мөн боловч ямар нэг объектыг тэмдэглэдэггүй, оюун ухаантай байна гэдэг бол ямар нэг тодорхой юмтай байна гэсэн үг биш, харин тодорхой нэг чадвар, дотоод оюунлаг шинж чанартай байгаа хэрэг гэж тайлбарласан.

Бехавиористууд оюун санааны төлөв дэх аливаа үйл явц бүр цаанаа физик төлөв болж байгаа үйл явдалтай холбоотой байдаг гээд, бусдын оюуны төлөвийн тухай мэдэж болох бүх зүйл тухайн хүний зан үйлээр дамжиж л хэрэгжих боломжтой, хувь хүний дотоод, хувийн ертөнцийн тухай аливаа хэллэгийг бүх нийтээр ажиглаж болох үйлдлүүд рүү хөрвүүлж болно хэмээдэг. "Би үнэхээр баяртай байна" гэвэл үүний гадаад илрэл нь "зүрхний цохилт нэмэгдэнэ, инээнэ, хацар улаа бутарна гэх мэт" байж болох аж. Хэдийгээр аливаа сэтгэл хөдлөл нь илэрхий гадаад шинж тэмдэг агуулах албагүй ч, сэтгэл хөдлөл болон оюун санааны аль нэг төлөв нь ямар нэг хэмжээгээр физик төлөв байдал руу хөрвүүлэгдэх ёстой. Ийнхүү бехавиористууд аливаа үйл явцыг хүний зан үйл рүү хөрвүүлж, энэ зан үйлээр нь дамжуулан оюуны үйл явцыг тодорхойлох боломжтой гэж үздэг байна.

Бехавиоризм олон дэмжигчидтэй боловч бас олон эсэргүүцэлтэй тулгардагийн зарим нь энэ онолын хангалттай үндэслэл болон холизмтай холбогдох ба эдгээр нь функционализмын үүсэлд чухал үүрэг гүйцэтгэжээ. Бехавиорист анализын хангалттай үндэслэлийн эсрэг янз бүрийн үндэслэл гарч ирсэн. Үнэндээ огт өвдөөгүй хэдий ч хүн тун үнэмшилтэйгээр жүжиглэн бүхий л холбогдох нөхцөлд тухайн өвчинтэй холбогдох бүхий

л замаар үйлдэл хийж харуулж болно. Мөн нэлээд стоик байдлаар дасгалжсан тамирчин хичнээн өвдөж байсан ч эсрэгээр өвдөлттэй холбоотой ямар ч үйлдэл хийхгүй байж болно. Ийм тохиолдолуудад үйлдэл нь оюуныг илэрхийлэх баримт болж чадахгүй аж.

Харин адилсалын онолын тухайд оюуны төлөв байдлуудыг тодорхой мэдрэлийн төлөвүүдтэй адилтгах зорилт тавьсан. Гол төлөөлөгчид нь Жон Смарт, Хэрбэрт Фейгл, Юллин Плэйс нар юм. Бехавиоризмын уналтанд хариу болон гарч ирсэн ба эдгээр философич оюуны төлөв нь ямар нэг зан үйл биш, гэхдээ материаллаг зүйл юм бол, тэр нь тархины дотоод төлөвтэй ижилхэн байж болох юм гэж үзсэн байна. Аяга кофе уумаар болох оюуны төлөв нь иймд тархины тодорхой хэсэг дэх тодорхой нейронууд идэвхижихээс өөр зүйл биш ажээ.

Ус нь H_2O , дулаан нь кинетик энерги болж хувирсан шиг, өвдөлт нь C-фибегын идэвхижил ч юм уу, мэдрэлийг судалдаг шинжлэх ухааны үүднээс тодорхойлогдож болох яман нэг зүйл болж хувирах ёстой гэж үзсэн. Ийм загварын үүднээс оюуны үйл явцууд нь ментал биш, физикийн шинжлэн ухааны үүднээс тайлж болох тодорхой физик шинж чанаруудтай адилхан байгаараа физик ертөнцөд өөрийн байр суурьтай байдаг. Товчхондоо энэ онолын үүднээс тархи ба оюун ухаан гэдэг бол адил зүйлс. Иймэрхүү адилсалуудыг гэрчлэх гол үндэслэл нь шууд бүртгэсэн хүний ментал төлөвүүд болон гурав дахь талаас эмпирик хэрэглүүдээр ажигласан тархины төлөвүүд хооронд илэрхий хамаарал байгаа явдал юм. Энэхүү хамаарлын энгийн тайлбар нь ердөө л хоёр ижил зүйлийг өөр өөр аргаар ажиглаж байж болох юм гэсэн дүгнэлт юм.

Бехавиоризмын нэгэн адил адилсалын онол нь мөн л өөрийн гэсэн дэмжигч ба эсэргүүцэгчидтэй. Адилсадын онолын эсрэг дэвшүүлсэн асуудлуудын дотроос multiple realization-ы тухай санаа функционализмын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэхүү эсэргүүцлийн гол үзэл санаа нь оюуны төлөвүүдийн мэдрэлийн үндэс нь янз бүрийн организмд, тэр бүү хэл нэг төрлийн организмын дунд ч ялгаатай байдаг гэсэн эмпирик магадлалаас эхэлдэг. Хүнд байгаа өвдөлт, гүрвэл болон наймаалжинд байгаагаас мэдрэлийн төвшинд ихээхэн ялгаатай бөгөөд иймээс өвдөлтийг multiple realization гэж ойлгож болох юм. Ингэхлээр өвдөлттэй холбоотой мэдрэлийн үндэс нь ийнхүү тухайн тохиолдол бүрт адилхан байдаг юм бол өвдөж байгаа гэсэн төлөвийг шууд аль нэг мэдрэлийн эд, эстэй адилтгаж болохгүй мэт. Ингэхлээр шүүмжлэгчидийн үзсэнээр оюуны төлөв болон физик төлөвийн хоорондын холбоо нь эдгээр нь нэг төрлийн "ижил", "адилхан" зүйл гэж үзэхэд хүргэх ёсгүй. Харин энэ нь нэг төрлийн realization-ы асуудал бөгөөд тухайн оюуны төлөвийг хэрэгжүүлэгч олон төрлийн физик сууриуд байдаг.

Оюун санааны философийн томоохон төлөөлөгч болох Нэд Блокийн тодорхойлсноор бехавиоризм бодит байдалтай зөрчилдөн хэтэрхий олон зүйлийг оюун ухаантай гэж тооцон хэт либерал байснаараа амжилтгүй болсон бол, эсрэгээр адилсалын онол нь бусад амьтад хүнтэй адил нейро-физиологийн шинж чанаргүй учраас бусад амьтад оюун ухаангүйгээр үл барам өвдөлт ч мэдрдэггүй хэмээн асуудалд хэт "консерватив" хандаж амжилтгүй болжээ.

Харин функционализмын хувьд аль аль дутагдалтай талыг нь даван туулжээ. Ингэхдээ функционализм ментал төлөвүүдийг организм болон системийг гадаад орчинтой нь холбож байдаг дотоод сүлжээний төлөв төлөв байдал гээд энэхүү системд гүйцэтгэх үүргээр нь тодорхойлсон байна. Ийнхүү тодорхой оюуны төлөвийн үүрэг нь тухайн

нөхцөл байдал буюу оролт, зан үйл буюу гаралттай холбоотой зүйл төдийгүй, бас бусад дотоод төлөвүүдтэй харилцах харилцааг нь агуулдаг байна.

Философи сэтгэлгээ ямагт тухайн цаг үеийнхээ ололт амжилтуудтай холбоотой байж, харилцан бие биендээ нөлөөлсөөр ирсэн. Логик позитивизмын хөгжил бехавиоризм хүчээ авахад хүргэсэн шиг когнитив болон оюуны үйл явцын талаархи мэдээлэлд тулгуурласан загвар бүтээх оролдлогууд үүссэн нь оюун ухаан бол системлэг, зохион байгуулалттай гэдэгт илүү ач холбогдол өгөхөд хүргэсэн байна. Компьютерын технологийн ерөнхий онолууд, техник хангамж болон программ хангамжийн зүйрлэлийг өргөнөөр хүлээн зөвшөөрсөн нь оюун санаа ба бие махбодын холбоог ч ижил байдлаар авч үзэх явдлыг дэвшүүлсэн.

Техник болон программ хангамжууд хоорондоо ямар харилцаатай байдаг шиг үйлдэл нь бүтэцдээ, оюун ухаан нь тархиндаа мөн л тийм хамааралтай. Ийнхүү 1960-аад онд тархины үйл явц нь оюуны үйл явц хэрэгжих субстрат нь болж өгдөг ба **оюун ухаан бол мэдээлэл боловсруулах систем** гэж үзэх болсон байна.

Нэг түвшинд, өөрөөр хэлбэл доод түвшинд бол компьютерт болж байгаа бүх зүйл техник хангамжаас хамаардаг боловч өөр нэг, өндөр түвшинд бол программ нь асуудлыг шийддэг байна. Жишээ нь, $3+7=10$. Түүхийн үүднээс аваад үзвэл, өөр өөр аргаар ажилладаг маш олон төрлийн төхөөрөмж, (hardware) байсан болохоор тооцоолох үйл явц бол түүний үйл ажиллагаа гэж хэлэхэд хэцүү. Иймээс функционалистууд тооцоолон бодох үйлдэл нь техник хангамжаар боломжтой болж байгаа гэж үздэг. Компьютерийн тухай энэ яриагаа бид оюун санааны тухай яриа луу хөрвүүлж болох бөгөөд ингэхлээр функционалистуудын үзлээр оюун санааны төлөвүүд нь тархины байж болох бүхий л функциональ төлөвүүд байдаг. Энэ төлөвүүд нь "гаралт" буюу зан үйлийг бий болгохын тулд "оролт"-уудтай бас өөр хоорондоо харилцан үйлчилдэг байна.

Функционализмын олон хувилбар оюуны төлөвүүд бол оюуны бусад төлөвтэйгөө бас хүртэхүйн "оролт", "зан үйлдлийн гаралт"-тай холбогдох шалтгаант холбоогоороо тодорхойлогдоно гэсэн нийтлэг сэдвийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл функционализм оюуны төлөвийг оюуны бус функциональ шинж чанартай нь холбон тодорхойлсоноор түүний физик хэрэгжилтийг зааглан авч үзжээ. Ингэхлээр функционализм тархины төлөв байдал бол оюуны төлөв байдлыг хариуцдаг боловч, тэдгээр нь яг адилхан гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Мэдрэлийн тогтолцоо, тархи бол оюуны олон янз байдал хэрэгжихэд тусалдаг бөгөөд энэ төлөвүүд нь тодохой зан үйлүүдийг бий болгодог байна.

Abstract: For several thousand years, philosophers and theologians have discussed about the nature of the human mind. Many fascinating theories have been proposed to give an explanation of the essence of mental states. Throughout most of that history, the dominant views have assumed that the mind is something quite mysterious and fundamentally unlike anything else in the natural world. On that assumption, the mind would not be the kind of thing that could be studied with the methods of science.

In this article, we have examined of functionalism, which is one of the influential theories in philosophy of mind. Although, functionalism is used in multiple areas of studies including sociology, psychology, architecture and linguistics, we have focused on the functionalist theory in philosophy of mind. We can find the root of functionalism in Aristotle's theory of the soul. In contrast to Plato's claim that the soul can exist apart from the body, Aristotle argued that the

(human) soul is the form of a natural, organized human body that is the set of powers or capacities that enable it to express its "essence".

In definition, functionalism in the philosophy of mind is the doctrine that what makes something a mental state of a particular type does not depend on its internal constitution, but rather on the way it functions, or the role it plays, in the system of which it is a part. In addition, functionalism is considered that it has successfully resolved the problems, which the both of behaviorism and identity theory have encountered with.